

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 16 өдөр

№.13/2023

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
нарийн бичгийн дарга томилох тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “Түмэн шувуут” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, санал хураалтын дүн, хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Болдбаатар овогтой Нямбаярыг 2023 ны 06 сарын 16-ний өдрөөс эхлэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын албан үүргээс чөлөөлж, мөн өдрөөс эхлэн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Дашцэрэнгийн Наранцэцэгийг томилсугай.
2. Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын танилцуулгыг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст байрлуулж, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, олон нийтэд мэдээлэх, ТУЗ-ын нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



..... Л.ЭРХЭМБАЯР
..... Б.ТУНГАЛАГ
..... Ж.БОЛД
..... Э.БАЯРЖАРГАЛ
..... Э.ЖАРГАЛХҮҮ
..... Б.БАРХАСБАДЬ
..... А.БАКЕЙ
..... Ц.НАРАН-УЧРАЛ
..... Г.МӨНХ-ЭРДЭНЭ